

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/166/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhhurtgelaudit02@gmail.com



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Зөвлөмж.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/457
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
П.НЯМДАВАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022-01/АДВАМБИЧНІГ 19000487

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,874,105.32</u>	<u>117,088,039.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,616,966.74
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	2,616,966.74
31120	Гадаад валют	-	2,616,966.74
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,616,966.74
31211	Төрийн сангийн харилцах	-	2,616,966.74
33	АВЛАГА	-	38,506,500.00
335	Бусад авлага	-	38,506,500.00
3351	Байгууллагаас авах авлага		38,506,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,874,105.32	75,964,572.54
351	Түүхий эд материал	17,221,901.32	31,078,851.04
35130	Эм боох материал	17,221,901.32	31,078,851.04
354	Хангамжийн материал	13,218,204.00	44,451,721.50
35410	Бичиг хэргийн материал	951,690.00	927,590.00
35420	Аж ахуйн материал	10,550,691.00	40,226,743.00
35460	Хүнсний материал	1,715,823.00	3,297,388.50
35600	Мал амьтад	434,000.00	434,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>610,998,747.53</u>	<u>633,998,489.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	610,998,747.53	633,998,489.61
392	Биет хөрөнгө	592,502,747.53	619,998,489.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	514,843,120.00	514,843,120.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,682,888.16)	(43,024,332.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,570,000.00	79,570,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,800,000.08)	(31,390,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,877,006.99	217,520,473.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(120,831,538.80)	(133,273,396.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,229,569.05	31,493,069.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,805,021.47)	(16,842,943.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,752,780.00	19,752,780.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,752,780.00)	(19,752,780.00)
39217	Ном	1,102,500.00	1,102,500.00
393	Биет бус хөрөнгө	18,496,000.00	14,000,000.00
39301	Програм хангамж	445,000.00	445,000.00
39302	Хасагдуулга	(445,000.00)	(445,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,496,000.00	14,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>641,872,852.85</u>	<u>751,086,528.89</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>641,872,852.85</u>	<u>751,086,528.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	661,388,636.04	577,802,177.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	661,388,636.04	661,388,636.04
51101	Өмч: - төрийн	661,388,636.04	661,388,636.04
512	Хуримтлагдсан үр дүн	(192,800,134.22)	(83,586,458.18)

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	(192,800,134.22)	(192,800,134.22)
51220	Тайлант үеийн үр дүн		109,213,676.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	173,284,351.03	173,284,351.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>641,872,852.85</u>	<u>751,086,528.89</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	464,102,125.91	984,656,285.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,360,043.91	316,700,121.32
120	Нийтлэг татварын бус орлого	67,327,473.91	294,074,101.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,327,473.91	294,074,101.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	67,308,973.91	294,074,101.32
122	Тусламжийн орлого	22,032,570.00	22,626,020.00
122001	Хандив тусламж /дотоод/	22,032,570.00	22,626,020.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	374,742,082.00	667,956,164.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	363,684,700.00	367,911,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	363,684,700.00	367,911,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,057,382.00	228,176,064.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,057,382.00	228,176,064.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	33,362,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		33,362,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	38,506,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	38,506,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	458,150,473.29	875,442,609.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,150,473.29	875,442,609.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,603,350.63	875,442,609.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,875,864.14	290,715,156.17
210101	Цалин	270,875,864.14	290,715,156.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,943,980.26	38,701,498.19
210201	Тэтгэврийн даатгал	26,432,199.33	27,350,448.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,129,136.51	2,907,149.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,633,685.03	2,325,721.89
210204	Ажилгүйдлийн даатгал	280,697.05	554,518.76
210205	Эрүүл мэндийн даатгал	4,468,262.34	5,563,658.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,189,995.00	33,480,309.00
210301	Гэрэл, цахилгаан	7,664,317.00	4,963,859.00
210302	Түлш, халаалт	21,199,678.00	28,159,450.00
210303	Цэвэр, бохир ус	326,000.00	357,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,779,324.00	23,013,407.00
210401	Бичиг хэрэг	1,357,690.00	1,038,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,723,470.00	18,106,977.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,487,664.00	1,243,480.00

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,210,500.00	2,624,350.00
2105	Нормативт зардал	26,854,751.23	66,203,038.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,941,903.73	52,795,523.94
210502	Хоол, хүнс	5,912,847.50	13,407,514.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,930,766.00	5,559,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,049,900.00	1,058,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,768,730.00	3,200,000.00
210604	Урсгал засвар	1,112,136.00	1,301,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,138,200.00	1,568,000.00
210702	Дотоод албан томилолт	1,138,200.00	1,568,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,602,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	920,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,288,470.00	416,201,700.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,203,882.99	373,790,475.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,084,587.01	42,411,224.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,547,122.66	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,547,122.66	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,547,122.66	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,951,652.62	109,213,676.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,951,652.62	109,213,676.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.04	(198,751,786.84)	635,921,200.24
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.04	(198,751,786.84)	635,921,200.24
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	5,951,652.63	5,951,652.63
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(192,800,134.22)	641,872,852.85
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(192,800,134.22)	641,872,852.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(192,800,134.22)	641,872,852.85
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	109,213,676.04	109,213,676.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	661,388,636.04	173,284,351.03	(83,586,458.18)	751,086,528.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	396,774,652.00	652,075,684.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>363,684,700.00</u>	<u>367,911,100.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,032,570.00	22,626,020.00
122	Тусламжийн орлого	22,032,570.00	22,626,020.00
122001	Хандив тусламж /дотоод/	22,032,570.00	22,626,020.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	374,742,082.00	629,449,664.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	330,822,300.00	367,911,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	330,822,300.00	367,911,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,057,382.00	228,176,064.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,057,382.00	228,176,064.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,862,400.00	33,362,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,862,400.00	33,362,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>389,308,852.00</u>	<u>649,458,717.26</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>389,308,852.00</u>	<u>649,458,717.26</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,761,729.34	648,450,717.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,475,194.87	290,794,956.76
210101	Үндсэн цалин	176,512,264.61	181,772,568.33
210102	Нэмэгдэл	71,797,430.26	70,330,491.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,700,000.00	4,395,000.00
210104	Урамшуулал	16,465,500.00	34,296,897.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,909,482.47	38,460,164.50
210201	Тэтгэврийн даатгал	26,397,701.54	27,871,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,129,136.51	2,615,301.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,633,685.03	2,155,247.58
210204	Ажилгүйдлийн даатгал	280,697.05	492,228.29
210205	Эрүүл мэндийн даатгал	4,468,262.34	5,325,887.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,189,995.00	33,480,309.00
210301	Гэрэл, цахилгаан	4,373,028.00	4,963,859.00
210302	Түлш, халаалт	24,461,167.00	28,159,450.00
210303	Цэвэр, бохир ус	355,800.00	357,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,723,470.00	22,425,480.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,723,470.00	18,105,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,320,480.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	19,198,782.00	22,486,840.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,898,782.00	14,486,600.00
210502	Хоол, хүнс	7,300,000.00	8,000,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,307,500.00	7,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,007,700.00	2,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,200,000.00	3,200,000.00

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,099,800.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,138,200.00	1,568,000.00
210702	Дотоод албан томилолт	1,138,200.00	1,568,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,082,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,400,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,737,105.00	232,034,967.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,737,105.00	232,034,967.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,547,122.66	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,547,122.66	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,547,122.66	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,465,800.00</u>	<u>(281,547,617.26)</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>7,465,800.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>7,465,800.00</u>	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,465,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	7,465,800.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,465,800.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,465,800.00)</u>	≡
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,616,966.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<u>2,616,966.74</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	427,528,900.00	421,282,653.26	6,246,246.74	98.54
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,528,900.00	421,282,653.26	6,246,246.74	98.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,528,900.00	421,282,653.26	6,246,246.74	98.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,528,900.00	421,282,653.26	6,246,246.74	98.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,383,200.00	290,794,956.76	2,588,243.24	99.12

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	183,497,600.00	181,772,568.33	1,725,031.67	99.06
210102	Нэмэгдэл	77,069,000.00	70,330,491.39	6,738,508.61	91.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000.00	4,395,000.00	897,000.00	83.05
210104	Урамшуулал	27,524,600.00	34,296,897.04	(6,772,297.04)	124.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,606,800.00	38,460,164.50	1,146,635.50	97.10
210201	Тэтгэврийн даатгал	27,871,500.00	27,871,500.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,933,800.00	2,615,301.44	318,498.56	89.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,100.00	2,155,247.58	191,852.42	91.83
210204	Ажилгүйдлийн даатгал	586,700.00	492,228.29	94,471.71	83.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,867,700.00	5,325,887.19	541,812.81	90.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,162,500.00	32,162,500.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,405,500.00	4,963,859.00	441,641.00	91.83
210302	Түлш, халаалт	26,400,000.00	26,841,641.00	(441,641.00)	101.67
210303	Цэвэр, бохир ус	357,000.00	357,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,605,000.00	22,425,480.00	179,520.00	99.21
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	18,105,000.00	18,105,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,320,480.00	179,520.00	88.03
210404	Ном, хэвлэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	24,386,600.00	22,486,840.00	1,899,760.00	92.21
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,486,600.00	14,486,600.00	-	100.00
210502	Хоол, хүнс	9,900,000.00	8,000,240.00	1,899,760.00	80.81
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,200,000.00	7,200,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,800,000.00	2,800,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,200,000.00	3,200,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,568,000.00	432,000.00	78.40
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,568,000.00	432,000.00	78.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,184,800.00	6,184,712.00	88.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,184,800.00	6,184,712.00	88.00	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	427,528,900.00	423,899,620.00	-	99.15
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	367,911,100.00	367,911,100.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	367,911,100.00	367,911,100.00	-	100.00

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,362,500.00	33,362,500.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	33,362,500.00	33,362,500.00	-	100.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	26,255,300.00	22,626,020.00	3,629,280.00	86.18
122001	Хандив тусламж /дотоод/	26,255,300.00	22,626,020.00	3,629,280.00	86.18
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,616,966.74	(2,616,966.74)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	228,176,064.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,176,064.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,176,064.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,317,809.00
210302	Түлш, халаалт	1,317,809.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,850,255.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	225,850,255.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	228,176,064.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	228,176,064.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,176,064.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00
620001	Удирдах ажилтан	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 9,163.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,872.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,616.9	2,616.9
Авлага	-	38,506.5	36,506.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	30,874.1	75,964.6	45,090.5
Үндсэн хөрөнгө	610,998.7	633,998.5	22,999.8
Нийт хөрөнгө	641,872.9	751,086.5	109,213.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	661,388.6	661,388.6	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	641,872.9	751,086.5	109,213.6

Авлага дансны үлдэгдэл 38,506.5 мянган төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас санхүүжүүлэх Ковид 19-тэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардлыг авлагаар тусгаснаас шалтгаалжээ. Эрүүл мэндийн газраас авах 38,506.5 мянган төгрөгийн авлагын эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75,964.6 мянган төгрөг болж, 45,090.5 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүд нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 176,846.9 мянган төгрөгийн вакцин, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, Ази фарм ХХК-аас 355.8 мянган төгрөгийн эм бэлдмэл, Лүн сумын Засаг даргын Тамгын газраас 33.7 мянган төгрөгийн оношлуур, автомакс, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдөөс 2,480.0 мянган төгрөгийн халдвар хамгааллын хувцас хэрэглэл, Иргэдээс 30,494.9 мянган төгрөгийн халдвар хамгааллын хувцас хэрэглэл,

дархлаажуулалтын түргэвчилсэн оношлуур, хүнсний материал, 1 иргэнээс өгсөн 250.2 мянган төгрөгийн мах, нийт 244,175.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 633,998.5 мянган төгрөг болж, 22,999.8 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс Ковид 19 цар тахалтай холбоотой хандиваар ирсэн хөрөнгүүдээр нэмэгдсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн газраас 28,213.1 мянган төгрөгийн компьютер суурин, хөлдөлт тандах заагуур, хэм хяналтын электрон хэрэгсэл, шинжилгээний пос машин, яаралтай тусламжийн тэргэнцэр, вакцины хөргөгч, вакцины зөөврийн сав, Лүн сумын Засаг даргын Тамгын газраас 1,500.0 мянган төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, Лүн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1999 оны төгсөгчдөөс 11,180.0 мянган төгрөгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, шарлагын аппарат, нярайн шарлагын аппарат, Хос гарьд ХХК-аас 2,170.0 мянган төгрөгийн кондешин ком, нийт 49,898.8 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Үндсэн хөрөнгийн данс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор хуучин эмнэлгийн байрын газрыг Сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн 4,496.0 мянган төгрөгөөр, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 тоот тогтоолоор 18,000.0 мянган төгрөгийн өртөгтэй УАЗ-469 маркийн автомашиныг актлан данснаас хассан дүнгээр нийт 2,496.0 мянган төгрөгөөр хасагджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 520,554.2 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дансанд хандиваар ирсэн 49,898.9 мянган төгрөгийн, бараа материалын дансанд хандиваар ирсэн 244,175.2 мянган төгрөгийн, нийт 294,074.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг үндсэн 4 тусламж үйлчилгээний санхүүжилт 22,626.0 мянган төгрөгийг, Ковидын санхүүжилтэд авах 38,506.5 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын байгууллагаас авах орлогоор тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 417,292.2 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нормативт зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эм бэлдмэл, нэг хэрэглэдэг хамгаалалтын хувцасны зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 485,530.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 485,530.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 58,001.3 мянган төгрөгөөр бууруулж, 427,528.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 427,528.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 367,911.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 33,362.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, тусламжийн эх үүсвэрээс 26,255.3 мянган төгрөгийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 367,911.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 33,362.5 мянган төгрөгийн, тусламжийн эх үүсвэрээс 22,626.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 421,282.6 мянган төгрөгийг зарцуулж, 2,616.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 228,176.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 228,176.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас Ковид-19 өөр хэвтэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтад хамрагдсан, дархлаажуулалтад хамрагдсан өвчтөнүүдийн эмчилгээ үйлчилгээний төлбөрийн 221,014.5 мянган төгрөгийг санхүүжүүлжээ.

Нэмэлт санхүүжилтээр сүрьеэгийн сорьц тээвэрлэсний зардал 87.1 мянган төгрөг, шатахууны 300.0 мянган төгрөг, Иргэдийн хандиваар өгсөн 2,087.0 мянган төгрөг, шинжилгээний орлого 2,188.0 мянган төгрөг, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас саагийн дархлаажуулалтын томилолтын зардалд 173.6 мянган төгрөг, тандалт судалгаанд 1,008.0 мянган төгрөг, халаалтын зардалд 1,317.8 мянган төгрөг, нийт 7,161.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 520,554.2 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дансанд хандиваар ирсэн 49,898.9 мянган төгрөгийн, бараа материалын дансанд хандиваар ирсэн 244,175.2 мянган төгрөгийн, нийт 294,074.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 417,292.2 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нормативт зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна. Энэ нь Ковид 19-тэй холбоотой эм бэлдмэл, нэг хэрэглэдэг хамгаалалтын хувцасны зарцуулалт нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 750,321.6 мянган төгрөгийн 46 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 467,018.0 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 28,907.9 мянган төгрөгийн 1 алдаа зөрчлийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	28,907.9	1	28,907.9	-	-	100
Нийт дүн	2	28,907.9	2	28,907.9	-	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 492,912.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20,008.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 26.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,859.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 467,018.1 мянган төгрөгийн шилэн данстай холбоотой зөвлөмж болон үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын зардлын дүнд худалдан авсан 20,008.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлагнаагүй, үндсэн үйл ажиллагааны зардалд тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар,

энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 хавсралтын 6.9-д “Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт „, үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд болон капиталжих их засварт зарцуулсан мөнгөн зардлыг харуулна”, санхүүгийн тайлангийн аудитын “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Давхар ажил эрхэлдэг 1 ажилтны цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцоноос 26.2 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, 7.1.6-д “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” заалтыг үндэслэн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Байгууллага нь нийт 7 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 5,379.7 мянган төгрөгийн, 1 хувь хүнтэй холбоотой 480.0 мянган төгрөгийн, нийт 5,859.7 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал ” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 148 ширхэг 151,676.9 мянган төгрөгийн биет хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", санхүүгийн тайлангийн аудитын "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Лүн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 750,321.6 мянган төгрөгийн 46 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 467,018.0 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Худалдан авсан хөрөнгийг мөнгөн гүйлгээний хөрөнгө оруулалтын дүнд тусгаагүй	1	20,008.1	1	20,008.1						
3	Цалинг буруу тооцоолж олгосон	1	26.2			1	26.2				
5	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	5,859.7					1	5,859.7		
6	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		4	25,894.0	1	20,008.1	1	26.2	1	5,859.7	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	467,018.1							1	467,018.1
Дүн		1	467,018.1								
Нийт дүн		5	492,912.1	1	20,008.1	1	26.2	1	5,859.7	2	467,018.1